

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

|  |      |
|--|------|
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>        | 1-4  |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 5-10 |

---

|   |      |
|---|------|
| <i>1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i> | 5-10 |
|---|------|

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны  
12 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Идэрбат, Ц.Сэргэлэн;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.

**Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, мөн яамны Цахим хөгжил, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Г.Батбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

***1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:***

**Э.Батшугар:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

***2.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:***

**Э.Батшугар:** Төслийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалт 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4/уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих, дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршлага, ноу-хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршлага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх;

6/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо /Э.Батшугар/-нд даалгасугай.” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**1.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авч болно.” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 18 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 10 цаг 24 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
10 цаг 06 минут.

### **ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батиугар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

28 дугаар тойрог Батиугар, 22 дугаар тойрог Саранчимэг, 29 дүгээр тойрог Доржханд, 23 дугаар тойрог Чинбүрэн, 28 дугаар тойрог Учрал, 13 дугаар тойрог Ундрэм. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Төрийн үйлчилгээний цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг нь арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу. Ундрэм гишүүнээр тасалъя. Ундрэм гишүүний микрофоныг өгье.

**Ч.Ундрэм:** Энэ сүүлийн үед нийгэмд цахим мөрийтэй тоглоомтой холбоотой хэргүүд, асуудлууд маш их гарч байна. Маш олон байгууллагууд нэг талаасаа хууль бусаар энийг зохион байгуулж байна. Нөгөө талаасаа оролцож байгаа хүмүүс нь ч гэсэн энэ хууль бус үйл ажиллагаанд оролцож байна. Тэгээд үүнээс болоод маш олон залуучууд ажил, амьдралаа алдаж байна. Гэр бүлүүд салж байна. Цахим мөрийтэй тоглоом тоглож байгаад өрөнд орчхоод тэрнээсээ болоод давхар дам гэмт хэрэг хийгээд байгаа ийм асуудлууд маш их гарч байна. Тэгэхээр бид нар энэтэй яаралтай энэ одоо манай Байнгын хороо, парламент арга хэмжээ авахгүй бол энд бүүр донтчихсон, ажил амьдралаа алдчихсан, гэр орноо алдчихсан, улмаар бүүр цаашилаад өчнөөн гэмт хэрэг хийгээд шоронд орох хэмжээний болчихсон олон залуучууд бидний ирээдүй өртөөд байна.

Тийм учраас үүнийг өнөөдөр ч юм уу ойрын хугацаанд Байнгын хороон дарга аа бид нар яаралтай хэлэлцэх шаардлагатай гэж үзэж байна.

**Э.Батиугар:** Цахим бооцоот тоглоом болон Бооцоот тоглоом, морин тойргийн хууль Засгийн газраас өргөн барьсан байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор Хууль зүйн байнгын хорооноос ажлын хэсэг гарчихсан. Морин тойргийн ажлын хэсгийг Б.Энх-Амгалан гишүүн ахалж байгаа. Оюунчимэг гишүүн бол энэ бооцоот тоглоом болон бусад энэ онлайн бэт гэх мэтчилэн зүйлтэй холбоотойгоор ажлын хэсгийг ахалж байгаа.

Тэгэхдээ бас манай Байнгын хороо үүнийг бас хэлэлцэх нь зөв гэж бодож байна. Ялангуяа энэ цахим мөрийтэй тоглоом, эксбет болон бусад онлайн покер гэх мэтчилэн зүйлүүд манай Монгол Улс, нийгэмд ихээр гарч байна. Ялт ч үгүй олон гэр бүл болон хүмүүс хохирч байна л даа. Тэгээд заавал хаах гээд хууль бусаар гэх болгосон мөртөө “би ни эн” ашиглаад ямар нэгэн байдлаар

ороод байдаг. Тэгэхээр энийг хаагаад, “би ни эн” хаагаад үнэхээр хэцүү гэдгийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр ямар нэгэн зохицуулалт хэрэгтэй гэдэг нь л хамгийн чухал. Яг л койнтой л адилхан зүйл шүү дээ энэ бол. Ажлын хэсгээс нэмж хариулах уу үүн дээр. Цахим яамнаас Тэнгис зөвлөх, 3 номерын микрофоныг нээе.

**С.Тэнгис:** Ундрам гишүүний асуултад тодруулж хариулъя. Цахим орчинд ер нь бусад орчин ч гэсэн энэ мөрийтэй болон мөнгө тавьж, бооцоо тавьж тоглох асуудал ер нь их дэлгэрээд, түгээмэл болоод бас л асуудал болоод байгаа нь үнэн. Энэтэй тэмцэх арга хэмжээг бол Цахим хөгжлийн яам эрхлэх асуудлынхаа хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа. Мөн Эрүүгийн хуульд бас заасан энэ бол өөрөө бас гэмт хэргийн хариуцлагатай нэг зүйл байгаа. Эрүүгийн хуулийн 20.17.1-д зааснаар олон нийтийн газар эсвэл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хэзэр, бусад зүйлсийг ашиглаад үр дүнг нь урьдчилж төсөөлөх боломжгүй аз туршиж тоглож байгаа тоглоомын хэлбэр гэвэл мөрийтэй тоглоом гэж үзээд үүний хуулиар хориглосон.

Тэгэхээр энийг одоо илрүүлэх, таслан зоосон авах ажил нь бол Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, сүүлд бас шинээр Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв байгуулсан. Байнгын ажиллагаатай. Тэгэхээр институт тогтолцооны хувьд төрийн эдгээр байгууллагууд хамтарч ажиллаж байгаа.

Нөгөө талаасаа мөн хүүхэд, залуучуудын цагаа чөлөөтөө зөв, боловсон өнгөрүүлэх бусад нөхцөл байдлыг бүрдүүлэх, мөн иргэдийн тоон бичиг үсэг, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр бас ийм тасралтгүй байнгын бас арга хэмжээ авах нь олон улсад шалгарсан

шийдэл байдаг. Тэгэхээр үүн дагуу Цахим хөгжлийн яам 23 болон 24 оныхоо үйл ажиллагааны төлөвлөгөөнд энэ иргэдийн тоон бичиг үсгийн боловсролыг нэлээн анхаарч, цахим үндэстэн гэдэг ийм хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

**Э.Батшугар:** Баярлалаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамтран өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн танилцуулна. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 23 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 23 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэлээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл дээр дээр дурдсан зарчмын зөрүүтэй саналуудыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүнд баярлалаа. Одоо ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын

байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх, ажлын дэд хэсгийн гишүүн, Батмөнх Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх, ажлын дэд хэсгийн гишүүн, Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Билигдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжил, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батбилиг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн мэргэжилтэн.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүдэд тараасан байгаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Алга байна. 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсрох чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 2 санал хураалт байгаа.

1.Нийтийн мэдээлэл ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулалт тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор хэлэлцье.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр



зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт одоо явуулъя.  
Санал хураалт.

Санал хураалт 57.1 хувиар дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. “Хууль батлагдсантай холбогдон авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол хэлэлцье.

1.Төслийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ-т даалгасугай.

1/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн

хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авах, аван хэрэгжүүлэх;

3/үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалт 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4/уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих,

дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршилага, ноу-хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршилага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх;

б/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо Э.Батиугар-д даалгасугай.”

Одоо санал хураалт явуулъя.  
Санал хураалт санал.

83.3 хувиар дэмжигдлээ.

2023 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үеэр хуралдаан даргалагчаас өгсөн гүйцэт боловсруулах чиглэлийн дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. 2 санал хураалт байгаа.

1.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолоор хэлэлцье.

1.Төслийг хууль санаачлагч буцаах.  
Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал 83.3 хувиар дэмжигдлээ.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг томъёоллыг хэлэлцье.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно” гэснийг “гэрчилгээний мэдээллийг төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглаж авч болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя санал.

83.3 хувиар дэмжигдлээ. Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Ганцхан, нэг протоколд тэмдэглүүлэх зүйл байна.

Эрхэм гишүүд ээ,

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар тусгасан зарим зохицуулалт, 1 дүгээр зүйлд нэмэлтээр орохоор байгаа. Энэ техник шинжтэй засварыг хийж та бүхэнд тараасан байгаа шүү. Үүнийг протоколд тэмдэглүүлье.

Тэгэхлээр энэ хуулийнхаа юуг та бүхэн үзээрэй. Тэгэхлээр энэ Эрүүл мэндийн хуульд өөрчлөн найруулах гээд 8.2 гэсэн бол энэ өмнө нь нэмж байгаа 8.1 гэдэг заалт орсон. Энийг анхааралдаа аваад протоколд тэмдэглүүлж байгаа шүү. Баярлалаа.

**Э.Батиугар:** Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн

даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамтран өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Их Хурлын гишүүддээ болон ажлын хэсэгтээ маш их баярлалаа.

10.24 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР